



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 02 дугаар сарын 13

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.17

№

2/59

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Баянхонгор аймгийн ХХААГ-ын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 171,925.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6877 метр квадрат талбай бүхий газар эзэмших эрхээс

• 005020058

тус байгууллагад 118,275.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4731 метр квадрат хэсгийг балансаас баланст шилжүүлэн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 32 зорилт, 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг МЭЕГ-аас 84.0 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>159,787,317.02</u>	<u>170,362,374.22</u>
33	АВЛАГА	1,100,000.00	1,100,000.00
335	Бусад авлага	1,100,000.00	1,100,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,100,000.00	1,100,000.00
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	151,487,317.02	169,262,374.22
351	Түүхий эд материал	112,453,862.55	129,684,502.31
35110	Тусгай зориулалттай материал	96,231,545.12	90,970,661.61
35130	Эм боох материал	16,222,317.43	38,713,840.70
354	Хангамжийн материал	38,048,454.47	37,767,871.90
35410	Бичиг хэргийн материал	9,424,975.00	7,027,175.00
35420	Аж ахуйн материал	23,674,717.00	24,054,873.00
35430	Сэлбэг хэрэгсэл	860,000.00	660,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,627,172.47	599,283.90
35470	Бусад хангамжийн материал	2,461,590.00	5,426,540.00
35600	Мал амьтад	985,000.00	1,810,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,292,101,605.49</u>	<u>1,172,149,754.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,292,101,605.49	1,172,149,754.96
392	Биет хөрөнгө	1,290,802,855.43	1,031,826,004.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	64,691,600.00	64,691,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,237,329.56)	(34,983,106.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	616,913,629.67	616,913,629.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(174,954,523.32)	(249,132,291.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	969,349,657.68	973,379,176.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(212,781,808.58)	(383,234,349.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,452,700.00	68,452,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,631,070.46)	(24,261,354.60)
393	Биет бус хөрөнгө	1,298,750.06	140,323,750.06
39301	Програм хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(981,249.94)	(981,249.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	139,025,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,451,888,922.51</u>	<u>1,342,512,129.18</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>5,561,133.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,561,133.40
413	Өглөг	-	5,561,133.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,619,133.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	942,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,451,888,922.51</u>	<u>1,336,950,995.78</u>

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
51	Засгийн газрын хувь оролцоо	1,451,888,922.51	1,336,950,995.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	139,025,000.00
511001	Өмч: - төрийн	-	139,025,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,397,211,272.44	1,143,248,345.71
51210	Өмнөх үеийн үр дүн	1,397,211,272.44	1,397,211,272.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	(253,962,926.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,677,650.07	54,677,650.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,451,888,922.51	1,342,512,129.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,491,767,914.83	2,325,228,104.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,695,874,434.83	558,371,988.28
120	Нийтлэг татварын бус орлого	1,695,874,434.83	558,371,988.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,695,874,434.83	558,371,988.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,297,100.00	2,528,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,693,577,334.83	555,843,588.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,795,893,480.00	1,766,856,115.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	894,806,800.00	959,691,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	894,806,800.00	959,691,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	901,086,680.00	807,164,515.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,193,000.00	657,112,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,893,680.00	149,644,055.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	408,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,797,686,188.75	2,578,776,030.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,797,686,188.75	2,578,776,030.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,785,365,048.35	2,527,963,239.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567,744,232.00	559,837,160.00
210101	Үндсэн цалин	443,782,435.00	434,852,071.00
210102	Нэмэгдэл	59,860,623.00	74,217,831.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,177,919.00	39,002,999.10
210104	Урамшуулал	14,923,255.00	11,764,258.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,252,444.00	70,383,922.00
210201	Тэтгэврийн даатгал	55,048,544.00	46,681,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,801,000.00	5,491,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,640,800.00	6,128,322.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,160,200.00	1,098,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,601,900.00	10,983,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,200,012.00	25,802,377.00
210301	Гэрэл, цахилгаан	1,586,900.00	1,814,129.00

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210302	Түлш, халаалт	21,600,000.00	21,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,013,112.00	2,388,248.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,655,549.53	41,914,095.57
210401	Бичиг хэрэг	4,394,050.00	6,141,200.00
210402	Тээвэр, шатахуун	29,084,571.53	22,651,004.56
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,900.00	3,909,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	219,000.00	178,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,747,000.00	3,067,400.00
210408	Бараа материал акталсны зардал	26,010,028.00	5,965,991.01
2105	Нормативт зардал	980,577,675.47	732,850,501.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	980,577,675.47	732,850,501.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,299,500.00	7,036,200.00
210604	Урсгал засвар	5,299,500.00	7,036,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,300,000.00	4,320,000.00
210702	Дотоод албан томилолт	2,300,000.00	4,320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	891,053,930.00	821,909,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	884,839,300.00	812,120,890.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	82,000.00	64,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	720,000.00	605,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,080.00	880,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	856,450.00	335,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,740,000.00
210807	Газрын төлбөр	556,100.00	164,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,281,705.35	263,909,293.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	902,924.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167,281,705.35	263,006,369.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,321,140.40	50,812,791.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,382,000.00	46,050,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	45,476,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,382,000.00	573,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,939,140.40	4,762,391.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,939,140.40	4,762,391.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>694,081,726.08</u>	<u>(253,547,926.73)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	415,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	415,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(415,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>694,081,726.08</u>	<u>(253,962,926.73)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,798,190,580.00</u>	<u>1,769,384,515.80</u>

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,297,100.00	2,528,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,297,100.00	2,528,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,297,100.00	2,528,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,297,100.00	2,528,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,795,893,480.00	1,766,856,115.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	894,806,800.00	959,691,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	894,806,800.00	959,691,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	901,086,680.00	807,164,515.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,193,000.00	657,112,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,893,680.00	149,644,055.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	408,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,798,190,580.00	1,769,384,515.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,798,190,580.00	1,769,384,515.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,785,869,439.60	1,718,470,324.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567,744,238.00	556,952,848.60
210101	Үндсэн цалин	443,782,435.00	431,967,759.60
210102	Нэмэгдэл	59,860,618.00	74,217,831.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,177,930.00	39,002,999.10
210104	Урамшуулал	14,923,255.00	11,764,258.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,313,100.00	68,649,100.00
210201	Тэтгэврийн даатгал	55,109,200.00	46,681,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,801,000.00	5,491,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,640,800.00	4,393,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,160,200.00	1,098,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,601,900.00	10,983,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,200,012.00	25,802,377.00
210301	Гэрэл, цахилгаан	1,586,900.00	1,814,129.00
210302	Түлш, халаалт	21,600,000.00	21,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,013,112.00	2,388,248.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,292,250.00	23,952,300.00
210401	Бичиг хэрэг	5,878,150.00	3,568,800.00
210402	Тээвэр, шатахуун	13,558,900.00	13,473,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,900.00	4,209,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	219,000.00	178,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,835,300.00	2,521,900.00
2105	Нормативт зардал	1,798,900.00	20,043,070.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,798,900.00	19,443,070.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,956,800.00	7,687,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,690,000.00

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210604	Урсгал засвар	4,956,800.00	5,997,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,300,000.00	3,378,000.00
210702	Дотоод албан томилолт	2,300,000.00	3,378,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,077,264,139.60	1,011,136,749.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,063,849,509.60	1,008,547,949.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	82,000.00	64,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	720,000.00	605,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,080.00	880,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	856,450.00	335,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	556,100.00	164,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	868,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	868,380.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,321,140.40	50,914,191.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,382,000.00	46,151,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	45,476,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,382,000.00	675,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,939,140.40	4,762,391.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,939,140.40	4,762,391.20
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	703,129,546.36	0.00	757,807,196.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	54,677,650.07	703,129,546.36	0.00	757,807,196.43
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	694,081,726.08	0.00	694,081,726.08
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	1,397,211,272.44	0.00	1,451,888,922.51
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	1,397,211,272.44	0.00	1,451,888,922.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	54,677,650.07	1,397,211,272.44	0.00	1,451,888,922.51
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	139,025,000.00	0.00	0.00	0.00	139,025,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-253,962,926.73	0.00	-253,962,926.73
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	139,025,000.00	54,677,650.07	1,143,248,345.71	0.00	1,336,950,995.78

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	966,191,600.00	959,848,115.60	6,343,484.40	99.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,191,600.00	959,848,115.60	6,343,484.40	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	920,039,800.00	913,696,315.60	6,343,484.40	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,285,700.00	556,952,848.60	4,332,851.40	99.2
210101	Үндсэн цалин	460,704,500.00	431,967,759.60	28,736,740.40	93.8
210102	Нэмэгдэл	63,617,800.00	74,217,831.90	(10,600,031.90)	116.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,871,000.00	39,002,999.10	(14,131,999.10)	156.8
210104	Урамшуулал	12,092,400.00	11,764,258.00	328,142.00	97.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,316,800.00	25,802,377.00	514,423.00	98.0
210301	Гэрэл, цахилгаан	1,871,700.00	1,814,129.00	57,571.00	96.9
210302	Түлш, халаалт	22,322,200.00	21,600,000.00	722,200.00	96.8
210303	Цэвэр, бохир ус	2,122,900.00	2,388,248.00	(265,348.00)	112.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,711,600.00	4,209,700.00	501,900.00	89.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,020,000.00	2,521,900.00	(501,900.00)	124.8
2105	Нормативт зардал	20,044,000.00	20,043,070.00	930.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,443,800.00	19,443,070.00	730.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,200.00	600,000.00	200.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,697,600.00	7,687,500.00	10,100.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,697,600.00	1,690,000.00	7,600.00	99.6
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,997,500.00	2,500.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,550,000.00	3,378,000.00	172,000.00	95.2
210702	Дотоод албан томилолт	3,550,000.00	3,378,000.00	172,000.00	95.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	206,544,300.00	206,362,740.00	181,560.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	203,944,500.00	203,773,940.00	170,560.00	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	346,100.00	335,100.00	11,000.00	96.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	868,380.00	1,131,620.00	43.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	868,380.00	1,131,620.00	43.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	959,691,600.00	957,319,715.60	2,371,884.40	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	959,691,600.00	957,319,715.60	2,371,884.40	99.8
122005	Орон нутгийн төсвөөс	959,691,600.00	957,319,715.60	2,371,884.40	99.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,500,000.00	2,528,400.00	3,971,600.00	38.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	57.00	47.00	10.00	82.5

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	57.00	47.00	10.00	82.5
620002	Гүйцэтгэх ажилтан	54.00	43.00	11.00	79.6
620003	Үйлчлэх ажилтан	2.00	3.00	(1.00)	150.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	804,774,009.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	804,774,009.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	804,774,009.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,774,009.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	804,774,009.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,390,506.80
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,390,506.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,7164,515.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,7164,515.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	657,112,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,644,055.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	408,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллага юм.

Тус газар нь мал амьтны эрүүл мэнд, захиргаа, санхүү, лаборатори, мал эмнэлгийн тасаг гэсэн 4 нэгжтэй, 47 орон тоотой үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт 966,191.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Л.Оюун-Эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Цэнд-Аюуш нар зурж, нярваар 3.Мягмардаш ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн.
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны дотоод аудитын нэгж нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаандаа мөрддөг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,342,512.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 109,376.8 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	8,300.0	1,100.0	(7,200.0)
Бараа материал	151,487.3	169,262.4	17,775.1
Үндсэн хөрөнгө	1,721,687.6	1,864,742.1	143,054.5
Хуримтлагдсан элэгдэл	(429,585.9)	(692,592.3)	(263,006.4)
Нийт хөрөнгө	1,451,888.9	1,342,512.1	(109,376.8)
Өр төлбөр	-	5,561.1	5,561.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,451,888.9	1,336,950.9	(114,938.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,451,888.9	1,342,512.1	(109,376.8)

Дээрх хүснэгтээс харахад, тайлант оны эхэнд 8,300.0 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд “Open gov” программыг ашиглалтад оруулснаар 7,200.0 мянган төгрөгийн авлага барагдаж, харин “Синапс” ХХК-аас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгөөс лабораторийн барилга баригдаж дууссаны дараа ашиглах хөрөнгийг аваагүй тул 1,100.0 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 169,262.4 мянган төгрөг болж өмнөх оноос 17,775.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 244,319.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, МЭЕГ-аас 551,259.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 771,977.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж Баянхонгор аймгийн МЭГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хөрөнгө актлах тухай” А/47 дугаар тушаалаар 5,965.9 мянган төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,172.1 мянган төгрөг болж 109,376.8 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 493 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн ХХААГ-ын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 171,925.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6877 метр квадрат талбай бүхий газар эзэмших эрхээс тус байгууллагад 118,275.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4731 метр квадрат хэсгийг балансаас баланст, МЭЕГ-аас 3 нэр төрлийн 4,029.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан, тайлант онд 263,006.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай тус тус холбоотой байна.

Тайлант оны эхэнд өр төлбөргүй, тайлант оны эцэст НДШ-ийн 1,982.7 мянга, ХХОАТ-ын 2,636.4 мянга, албан томилолтын 942.0 мянга, нийт 5,561.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 114,938.0 мянган төгрөгөөр буурч 1,336,950.9 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,002,371.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,004,371.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 286,225.3 мянган төгрөгөөр бууруулж, 718,145.7 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд тайлант хугацаанд 3 удаа тодотгол хийж 2022 оны 12 дугаар сард улсын төсвөөс 953,191.6 мянга, үйл ажиллагааны орлогоос 6,500.0 мянган төгрөг нийт 959,691.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 959,691.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 959,691.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн орлогоор 2,528.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, тандалт судалгааны зардлаас зарцуулагдаагүй үлдэгдэл 2,390.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны зардлаас 2,371.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 959,848.1 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,371.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	661,484.5	657,479.8	4,004.7	99.4
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	443,140.0	439,135.3	4,004.7	99.4
2	82504 малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	201,344.5	201,344.5	0	100.0
3	82510 Мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлт	17,000.0	17,000.0	0	100.0
	70805 Хөдөө аж ахуй газар тариалангийн бодлого	304,707.1	302,368.3	2,338.8	99.2
4	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	258,555.3	256,216.5	2,338.8	99.2
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	46,151.8	46,151.8	0	100.0
	Нийт	966,191.6	959,848.1	6,343.5	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна.

(мянган төгрөг)

№	Санхүүжилт олгосон байгууллага	Орлогын төрөл	Санхүүжилтийн дүн
1	Орон нутгийн орлогоос санхүүжилт	Мал эмнэлгийн үйлчилгээний хөлс	444,297.8
		Вакцины үнэ	188,831.7
2	АЗДТГ-аас А/135 дугаар захирамж	Шүлхий өвчин	1,632.9
3	АЗДТГ-аас А/363 дугаар захирамж	Ариутгал, халдваргүйжлийн бодис	22,350.0
4	Эрдэнэцогт сумын ЗДТГ	Шатахууны үнэ	378.0
5	Мал эмнэлгийн ерөнхий газар	Шүлхий өвчний дархлаажуулалтын үйлчилгээний хөлс	125,975.2
6	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	Бруцеллёзын хээлтүүлэгчийн тандалт	15,898.3

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		4 өвчний тандалт	3,723.9
		Шүлхийн вакцинжуулалтын дараах тандалт	4,046.7
7	Сүүтэй дөрөө ХХК		30.0
	Нийт дүн	-	807,164.5

Дээрх хөрөнгүүдийг зориулалтын дагуу зарцуулж УМЭАЦТЛ-иас олгосон санхүүжилтийн үлдэгдэл 2,390.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,797,686.2 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,797,686.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 41.965.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 29,375.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53 гүйлгээний 1,747,212.2 мянган төгрөгийн гүйлгээ мэдээлэхийг үнэн зөв мэдээлсэн, зарлагын 27 гүйлгээний 391,086.2 мянган төгрөгийг мэдээлэхээс 2 гүйлгээний 82,718.2 мянган төгрөгийн гүйлгээг илүү мэдээлсэн, мөн удирдлагын гаргасан хувь хүний нууцтай холбоотой тушаалуудыг байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулах, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг байршуулахдаа хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цаашид шилэн дансны цахим мэдээлэлд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16,520.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2 зөрчилд 985.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 15,535.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	
Албан шаардлага	2	985.0	2	985.0	100
Зөвлөмж	3	15,535.2	3	15,535.2	100

Нийт дүн	5	16,520.2	5	16,520.2	100
----------	---	----------	---	----------	-----

Бараа материалын хөрөнгийн дансанд мал тооллогын бүртгэгдээгүй 985.0 мянган төгрөгийн малыг бүртгэсэн, мөн санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй эзэмшил газрыг ТӨБЗГ-ын 2022 оны “Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 493 дугаар тогтоолоор орлого авч бүртгэсэн, зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар тус газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 190 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 942.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудит явцад залруулав.

1. Дотоод албан томилолтын зардлын тариф Сангийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар шинэчлэгдсэн байхад нягтлан бодогч өмнөх тарифаар олгож 12 хүнд 942.0 төгрөгийн томилолтыг дутуу олгосон бөгөөд өр төлбөрөөр тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд томилолтын 942.0 мянган төгрөгийн өглөгийг тусгаж залруулав.

Аудитаар нийт 7,049.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 561.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 5,561.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 926.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тайлант хугацаанд 6 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 40 хоногийн хоолны зардалд 200.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд хоолны мөнгөнд давхардуулан олгосон 200.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Тайлант хугацаанд 3 мэргэжилтэнд 2022 оны 5 дугаар сард албан томилолт, буудлын зардалд тус бүр 26.5 мянган төгрөг нийт 79.5 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 дэх “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, 2.8 дахь “Томилолтын хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн тохиолдолд хэтрүүлсэн хугацааны байр, хоолны зардлыг олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 79.5 мянган төгрөгийн томилолтын зардлыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3. Тайлант хугацаанд байгууллагын дарга суудлын автомашиныг хот доторх үйлчилгээнд унаж 519 километр 282.3 мянган төгрөгийн 92 литр шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж шатахууны зардалд зарцуулсан 282.3 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1. Тус байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 4,000.0 мянган төгрөгөөр нэмж тодотгосон, мөн 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр 8,000.0 мянган төгрөгийн санхүүжилт буцаан татсантай холбоотойгоор ХХОАТ, НДШ, томилолтын 5,561.1 мянган төгрөгийн өр төлбөрийг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг барагдуулах, цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага өгөв.

5.2.3 Өвлөмж

5.3.1. ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн “Бүтэц орон тоо батлах тухай” А/24 дүгээр тушаалаар сахиул, үйлчлэгчийг цалинг ТҮ-3 шатлал буюу 569,585 төгрөгөөр тогтоож 2 албан хаагчид нийт 926.3 мянган төгрөгийг цалин хөлсөнд илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх “Төрийн албан тушаалыг доор дурдсанаар ангилна”, 10.1.4 дэх “төрийн үйлчилгээний албан тушаал”, 10.4 дэх “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах албан тушаалын жагсаалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална”, Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”-ийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын цалин хөлсийг Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол, 2022 оны 488 дугаар тогтоолын дагуу тогтоож мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 27 гүйлгээний 391,086.2 мянган төгрөгийг мэдээлэхээс 2 гүйлгээний 82,718.2 мянган төгрөгийн гүйлгээг илүү мэдээлсэн.	1	0	0	0	0	0	1	0	0
Удирдлагын гаргасан хувь хүний нууцтай холбоотой тушаалуудыг байршуулсан байна.	1	0	0	0	0	0	1	0	0
Дүн	2	0	0	0	0	0	2	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	3	0	0	0	0	0	3	0	0

00000